



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2003 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2003 оны 7, 12 дугаар тогтоолыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ**:

Нэг. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дүрмийг нэгдүгээр, Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын дүрмийг хоёрдугаар, Газрын албаны дүрмийг түрэвдүгээр, Байгаль орчны газрын дүрмийг деревдүгээр, Мал эмнэлэг, үржлийн газрын дүрмийг тавдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдэж ажиллахыг дээрх хэрэгжүүлэгч агентлагийн дарга наарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

0200377

Нийслэлийн Засаг даргын 2003 оны
99.-р захирамжийн 11.-р хавсралт

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДҮРЮМ.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар / цаашид "Газар" гэх / нь нийслэлийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хууль тогтоомж болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын биелэлтийг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйзэр/ үйл ажиллагааг хянан шалгах эрх үүрэг бүхий орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага мөн.

1.2 Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын зорилт нь санхүүдаатгал, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, эрүүл ахуй, халдварт судлал, эм биобэлдмэл, эмчилгээ, хөдөлгөр, боловсрол, соёл, байгаль орчин, геодези зураг зүй, стандарт чанар, хэмжил зүй, барилга, авто зам, эрчим хүч, харилцаа, мал эмнэлэг, хорио цээр, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хүрээнд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг хануулахад оршино.

1.3 Газар, улсын байцаагчид нь үйл ажиллагаанд хуулийг дээдлэх, ил тод, шударга ёсиг хангах зарчмыг баримталж, Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, нийслэлийн Засаг дарга, Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон мөрднө.

1.4 Нийслэлийн нутаг дэвсгэрт мэргэжлийн хяналт / цаашид "хяналт" гэх-/ын нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч, улсын байцаагч / цаашид "улсын байцаагч" гэх/, байгаль хамгаалагч нар хэрэгжүүлнэ.

1.5 Газар нь Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад ажлаа тайлagnана.

1.6 Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага зохион байгуулалт

2.1 Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга, улсын байцаагчийн жишиг тоог Улсын мэргэжлийн хяналтын газар тус тус тогтооно.

2.2 Газрын улсын байцаагчийн эрхийг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга, бөгөөд улсын ерөнхий байцаагч олгоно.

2.3 Газрын даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшүүлцэж Улсын мэргэжлийн хяналтыг газрын дарга томилж, чөлөөлнө. Газрын дарга улсын ахлах байцаагч байна.

2.4 Газрын дарга нь батлагдсан бүтэц орон тооны дагуу, хэлтсийн дарга, төв лабораторийн зрхлэгч, хэсийн ахлагч, улсын байцаагч, мэргэжилтнүүдийг шууд, дэд дарлыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцэж тус тус томилж, чөлөөлно. Байгаль хамгаалагчийг батлагдсан нормативын дагуу томилж ажилтуулна.

2.5 Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын цалин, урамшуулалыг тогтоож, эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, журам, заавар гаргана.

2.6 Дэд дарга нь газрын даргаас шилжүүлсэн эрх, үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг нь хариуцна.

2.7 Газрын даргын дэргэд байгуулшын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гаргах, даргын шийдвэрийг бодитой гаргахад туслах үүрэг бүхий зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг азрын дарга тогтооно.

2.8 Газар нь дэргэдээ лабораторитой байна.

2.9 Налайх, Багануур дүүрэг дэх хяналтын салбаруудын ахлагчид нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулинд заасны дагуу Ерөнхий менежерийн бүрэн эрхэд хамаарах зарим эрхийг шилжүүлсэнээр удирдлагыг хэрэгжүүлнэ.

2.10 Газрын дурмийг Нийслэлийн Засаг дарга батална.

2.11 Газрын дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлэн төсвийг зарцуулна.

2.12 Газрын дарга нь газрын дэд дарга, Тамгын хэлтсийн дарга. Төв лабораторийн зрхлэгчтэй, эрхээ бичгээр шилжүүлсэн тохиолдолд дэд дарга нар нь бусад хэлтсийн дарга нартай, хэлтсийн дарга нь ажилтнуудтайгаа үр дүнгийн гэрээ байгуулж ажилана.

2.13 Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг дарга, Улсын мэргэжлийн хяналтын газрый үдирдлага дор явуулж хариуцан ажлаа тайллагнах бөгөөд Улсын мэргэжлийн хяналтын газар нь мэргэжил, арга зүйн үдирдлагаар хангана.

2.14 Газар нь үйл ажиллагааныхаа хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт хяналт шалгалт явуулахдаа холбогдох яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, газрууд, нутгийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тэдэнд шаардлагатай мэдээлэл өгөх, мэргэжил, арга зүйн үдирдлага, туслалицаа үзүүлнэ.

2.15 Газар нь эрхэлсэн хүрээний хяналт шалгалтын асуудлаа бие дааж шийдвэрлэхийн зэрэгцээ шаардлагатай асуудлаар бусад газартай хамтран ажиллана.

Гурав. Газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1 Газрын байцаагчид нь дор дурьдсан чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна. Үүнд:

- 3.1.1 Орон нутгийн төсвээс санхүүждэг хуулийн элзээдийн санхүү, аж ахуй үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- 3.1.2 Санхүү, тасов, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.3 Нийгмийн халамжийн тухай хууль тогтоожийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.4 Хөдөлмөр өрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.5 Хөдөлмөрийн тухай хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.6 Эрүүл мэндийн тухай хууль, Эмийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- 3.1.7 Эмчлэх, оношлох, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээний стандарт, технологийн хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт гаргах;
- 3.1.8 Бага, дунд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын эжлын түвшинд хяналт тавьж, дүгнэлт гаргах;
- 3.1.9 Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлт хадгалалт хамгаалалт, тэзвэрлэлт, худалдаа үйлчилгээтийн холбогдон гарсан хууль тогтоомж болон бусад стандарт дүрэм журмыг худалдаа үйлдвэр үйлчилгээний байгууллага, иргэд хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих;
- 3.1.10 Худалдаа, нийтийн хоолны газар, орчин, технологийн үйл ажиллагаа болон дээж авалт, хоолны технологийн картын мөрдлөт, хөтлөлт, ариун цэвэр, бараа материал; түүхий эдийн хадгалалтанд хяналт тавих;
- 3.1.11 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтын бүх шатанд технологи ариун цэврийн шаардлагын талаар дотоодын хяналтыг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих;
- 3.1.12 Мал амьтан болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн түүхий эд, тэжээл бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, боловсруулах, худалдаалах дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.13 Газар, газрын хэвлэй, түүний баялаг ус, ой, ургамал, агаарыг хамгаалах тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, ой, хээрийг түймрээс хамгаалахтай холбогдон гарсан хууль тогтоомж, стандарт, дүрэм, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих;
- 3.1.14 Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаа, тэдгээрийн тоног төхөөрөмжийн угсралт, засвар, зураг төсөл, ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм, журам стандартын хэрэгжилтэнд хяналт тавих;
- 3.1.15 Геологи уул уурхайн үйлдвэрлэл, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм журмын болон үйлдвэрлэлийн ослосс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

Дөрөв. Газрын эрх, үүрэг

4.1 Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгосон эрхийг хэрэгжүүлэхээс тадна, Нийслэлийн Засаг дарга, Улсын мэргэжлийн хяналтын газрын даргаас шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.2 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мэргэжлийн хяналтыг холбогдох хууль, тогтоомж, батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу үнэн бодитой, үр нөлөөтэй явуулна.

4.3 Газар нь мэргэжлийн хяналтыг боловсронгуй болгох, улсын байцаагч нарын мэдлэг үр чадварыг дээшлүүлэх талаар шат дараалсан арга хэмжээ авна.

4.4 Газар нь мэргэжлийн хяналтын үйлчилгээг түргэн шуурхай явуулах, иргэн байгууллага, аж ахуйн нэгжийн санал, өргөдөл, гомдлыг хуулинд заасан хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.

4.5 Газрын дарга нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлж хянуулна.

4.6 Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, териин албан хаагчдын ёс зүй хэм хэмжээт сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийг үр дүнгийн гэрээнд зааснаар зарцуулж ажиллах үүрэг хүлээнэ.

4.7 Үйл ажиллагааны хүрээний асуудлаар мэргэжлийн хяналт шалгалт хийж хууль тогтоомж зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдэд хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэх, хуулийн байгууллагад шилжүүлнэ.

4.8 Гадаад орнуудын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллана.

4.9 Газрын дарга нь албан ажлын автомашин хэрэглэнэ.

Тав. Улсын байцаагчийн бүрэн эрх

5.1 Улсын байцаагч нь төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.2 Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, дүгнэлт, акт, шийтгэвэр, торгуулиин хэвлэлмэл хуудас хэрэглэнэ.

5.3 Улсын байцаагч нь тухайн салбарын хяналт шалгалтын чиглэлээр мэргэшсэн байна.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1 Газрын дарга, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Улсын байцаагч нь хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Бусад зүйл

7.1 Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгальтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо эрх бүхий албан тушаалтан, улсын ерөнхий болон ахлах байцаагчид гаргана.

7.2 Хяналт шалгалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан гомдлыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна.Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгж эрх баригч, албан тушаалтан гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвэл гомдлоо шүүхэд гаргаж болно.

7.3 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлийг оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

Нийслэлийн Засаг даргын 2003 оны

99р захирамжийн

х-р хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар нь /цаашид газар гэх/ Нийслэлийн нутаг дэвсгэр дээр "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай", "Хот байгуулалтын тухай", "Барилгын тухай", "Авто замын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад тогтоол, шийдвэр, журам, дүрмийн хүрээнд Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх, нийслэл хот болон бусад газрын захиалгатай төсвийн болон төсвийн бус хөрөнгийн эх үүсвэрээр шинээр барих шинэчлэн өргөтгэх, барилга байгууламж, их засварт батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, захиалагч, техник хяналтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий орон нутгийн байгууллагаа мөн.

1.2 Газар нь үйл ажиллагааныхаа чиглэлүүдээр Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд ажлаа тайлagnана.

1.3 Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бөгөөд улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр үйл ажиллагаа явуулна.

1.4 Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.5 Газрын дарга нь Нийслэлийн Засаг даргатай зөвшүүлсний үндсэн дээр орлогч даргыг томилж, чөлөөлнө.

1.6 Газар нь ерөнхий инженертэй байна.

1.7 Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томиж, чөлөөлнө. Ажлын шаардлагаар түр гэрээгээр мэргэжлийн ажилтан авч ажиллуулж болно.

1.8 Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.9 Газар нь мэдээлэл, технологийн нэгдсэн сан болон архивтай байна.

1.10 Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

1.11 Газрын даргын дэргэд байгууллагын ойрын болон хэтийн зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэг бүхий зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга тогтоно.

1.12 Газар нь хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн хангамжийн талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий Барилга архитектур, техникийн зөвлөлтэй байна.

1.13 Газар нь шинээр барилга байгууламж барих газрын байршилт тогтоож, газар ашиглуулах эрх олгох асуудлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлүүлнэ.

1.14 Газар нь Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнтэй үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

Хоёр. Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын үүрэг

2.1 Газар нь Нийслэл Улаанбаатар хотын өрөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хот байгуулалт, барилгажилтын үйл ажиллагааг нэгтгэн зангидах, улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн зураг тесел, барилга угсралт, засварын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, нийслэлийн нутаг дэвсгэрт гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар баригдах бүх төрлийн барилга байгууламжид техникийн хяналт тавьж ажиллана.

2.2 Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн Иргэдийн Төлөвлөгчдийн хуралд оруулж батлуулна.

2.3 Хот байгуулалтын батлагдсан баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж шийдвэрлүүлнэ.

2.4 Нийслэлийн иргэн аюулгүй орчинд амьдрах шаардлагыг харгалзан Нийслэл Улаанбаатар хотод баригдаж байгаа өмчийн бүх төрлийн орон сууц, олон нийтийн үйлчилгээний барилгад захиалагчийн техник хяналт тавина.

2.5 Нийслэлд хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар хот байгуулалтын үйл ажиллагаанд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулна.

2.6 Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүх хөтөлбөр, төслийн хүрээнд хийгдэх судалгааны ажилд оролцон санал өгч, холбогдох материалуудыг архивт хадгалж, хэрэгжилтэнд хяналт тавина.

2.7 Нийслэлийн бус нутгийн хөгжлийн тесел, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн хүрээнд хийгдсэн инженер геологийн судалгаа, бусад зориулалтын зураглал, хилийн цэсийн баталгаат баримт бичгүүд, геодезийн цэг тэмдэгтүүд, зам тээвэр, инженерийн шугам сүлжээний хэтийн төлөвийн зураг тосол болон бусад холбогдох баримт бичгийг зохих шаардлагын хэмжээнд бүрдүүлж, нууцын болон архивын материалуудын иж бүрэн судалгаа, бүртгэл хөтөлж ашиглах, тодотгол, шинэчлэл хийх ажлыг зохион байгуулна.

2.8 Нийслэл хот болон алслагдсан суурингуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

2.9 Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга, байгууламжийг байршлын онцлог, үндэсний архитектурын уламжлал, орон зайн зохицлороо, зохиомжинд нийцүүлэн тухайлсан эзэлхүүн төлөвлөлтөөр хэрэгжүүлэх, тохижилт, зам талбай чимэглэл, үрлагийн бүтээлүүд архитектурын жижиг хэлбэрүүдийг цогцолбороор гүйцэтгэх ажлыг зохион байгуулна.

2.10 Архитектурын дэвшилтэй төлөвлөлт, орон зайд ашиглалтыг сайжруулах барилга угсралтын ажилд шинэ техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор төрийн бус мэргэжлийн байгууллагууд, уран бүтээлчид, инженер техникийн ажилчид, барилгачидтай хамтран ажиллана.

2.11 Хот байгуулалтын бодлогыг зах зээлийн эдийн засгийн нийтлэг хандлагад нийцүүлэн хот байгуулалтын эдийн засгийн үнэлгээ боловсруулж хэрэгжүүлэх, эдийн засгийн чөлөөт бүс, амраат жуулчлалын болон үндэсний парк зэрэг төслийдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий тосолтой уялдуулна.

2.12 Улс, нийслэлийн захилгаар шинээр барих, их засвар хийх, өргөтгөх бүх барилга байгууламж, шинээр барих, шинэчлэн өргөтгөх зам, гүүр, далан суваг болон инженерийн байгууламж, гэрэлтүүлгийн ажилд шаардлагдах хөрөнгийн хэмжээг тооцон хөрөнгө оруулалтын жилийн болон хэтийн төлөвлөгөөнд суулгуулж, зураг төслийг захиалан хийлгэж, захиалагч, техник хяналтыг хэрэгжүүлнэ.

2.13 Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хууль, уг хуулийг дагалдан гарсан заавар, журмын дагуу зхион байгуулж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлнэ.

2.14 Шинээр барих, өргөтгөх, засварлах, зам, гүүр, барилга, инженерийн байгууламжийн зургийн даалгаврын дагуу зураг төслийг захиалан хийлгэж, батлагдсан зураг ёсоор захиалагчтай гэрээ байгуулж, дүгнэн, улсын экспертиз хийнэ.

2.15 Хөрөнгө оруулалтын санхүүжилтын мэдээг сар бүр гаргаж холбогдох газруудад хүргүүлнэ.

2.16 Нийслэлд барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нехцел, найдвартай ажиллагааг хангах, эзүй зохистой ашиглах өрөнхий шаардлагыг тогтоох, техникийн хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг удирдан зхион байгуулж хэрэгжүүлнэ.

2.17 Нийслэлд шинээр баригдах, барилга байгууламжийн инженерийн хангамжийн техникийн нөхцлийн хэрэгжилтэнд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангана.

2.18 Хот байгуулалтын баримт бичгийн теслүүдийг олон нийтэд сурталчилж, санал авна.

2.19 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай барагдуулах, өргөдөл гомдолын барагдуулалтыг тухай бүр тайлagnаж байна.

2.20 Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалтыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулна.

2.21 Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

2.22 Тухайн жилд эзэмшил ашиглалтанд шинээр олгогдох газрын байршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөн жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна.

Гурав. Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын эрх

3.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

3.2 Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх үйл явц хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцэж буй эсэхэд хяналт тавих.

3.3 Газрын эрх бүхий ажилтнууд нь Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн барьж байгаа барилга объектуудад саадгүй нэвтрэн орж холбогдох хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, хотын ерөнхий төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, холбогдох бичиг баримтыг шаардах, шалгах.

3.4 Архитектур, хот байгуулалтын үнэт ёвийг илрүүлэх, бүртгэл хяналтад авах, хамгаалах, сэргээн засварлах, үндэсний архитектурын уламжлалыг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад санал оруулах, шийдвэр гаргуулах.

3.5 Нийслэлийн бус нутгийн онцлог, архитектур төлөвлөлт, барилгажилтын дүр төрхийг бий болгох, үндэсний архитектурын уламжлалыг сэргээх тохижилт, чимэглэл, зоо зүйн түвшинг дээшлүүлэх, гадаад доодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор сонгон шалгаруулалт явуулах, уран бүтээлийн уралдаан зарлан дүгнэх, сурталчлах, бүтээлийг хэрэгжүүлэх, уран бүтээлийн үзэсгэлэн гаргах, зөвлөгөөн, онол-практикийн бага хурал зохион байгуулах

3.6 Шинээр барилга объект барих, засварлах зэрэг ажлын гүйцэтгэгчийг ажлын шаардлагаар сонгоходоо “Төрийн болон орон нутгийн ёмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хууль, Монгол улсын Засгийн газраас баталсан “Бараа ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”ын дагуу зохион байгуулна.

3.7 Барилга байгууламж, их засварын ажлыг технологийн дараалал, батлагдсан зураг төслийг зөрчиж, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу хариуцлага тооцож, улсыг хохиронуй болгох арга хэмжээ авах

3.8 Хэрэв буруутай этгээд гаргасан зөрчил дутагдлаа арилгаагүй тохиолдолд тухайн байгууллагын барилга угсралт, их засварын ажлыг уг зөрчлийг арилгатал зогсоох арга хэмжээ авахуулах

3.9 Гүйцэтгэгч байгууллага тухайн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулснаас гарсан хохирлыг арилгуулахын тулд банк, санхүү, хуулийн байгууллагаар хянуулж шалгуулах

3.10 Барилга угсралт, их засварын ажлын техникийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага, зураг төслийн авторын оролцоотойгоор явуулж, зөрчил, доголдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд зохих хууль дүрмийн дагуу холбогдох байгууллагын хүмүүст хариуцлага хүлээлгэх асуудлыг тавьж шийдвэрлүүлэх

3.11 Барилга угсралт, их засварын ажил дууссаны дараа барилга ашиглалтанд оруулах комисст хүлээлгэн өгч, комиссоос тогтоосон гүйцэтгэгч байгууллагаас хариуцах чанарын баталгаат хугацааг мөрдүүлэх

3.12 Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, барилгын ажлын норм, норматив, үнэлгээний дагуу хянаж, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажилд тохирсон санхүүжилтын эрх нээх, санхүүжилт хийх, дутуу гүйцэтгэсэн ажлаас санхүүжилтийг хасах

3.13 Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, барилга угсралт, их засварын ажлын төсөвт нөхөн сэргээх ажлын зардлыг тусгуулж, түүний үндсэн дээр урьдын байдалд оруулах

3.14 Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа барилга угсралт, их засварын ажлын норм, норматив, үнэлгээ, зураг төсөлд оруулах санал боловсруулж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

3.15 Стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаагүй материал ашиглахыг хатуу хориглож, шаардлагатай бол эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулах

3.16 Хууль тогтоомж, хот байгуулалтын баримт бичиг, журам зэрчиж гаргасан албан тушаантны шийдвэрийн талаар дүгнэлт гаргах

3.17 Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудтай үйл ажиллагааныхаа чиглэлүүдээр хамтран ажилшана.

3.18 Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон үсад эрхийг эдлэх

Нийслэлийн Засаг даргын 2003 оны
99 дүгээр захирамжийн 3 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1.1 Нийслэлийн газрын алба /цаашид алба гэх/ нь газрын харилцаа, геолези, зураг зүйн талаарх хууль тогтоомжийг Нийслэлийн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, энэ чиглэлээр Нийслэлийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурал, Засаг даргын бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлж, тэдгээрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилго бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага-Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг мөн.
- 1.2 Алба нь газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын болон Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч дарга. Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, тэдгээрийн өмнө ажлаа тайлagnana.
- 1.3 Албаны үндсэн үүрэг нь Нийслэлийн газрын нэгдмэл сангийн газар зохион байгуулалт, газрын кадастрыг эрхлэх, газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглаулах ажлыг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, газар ашигласны төлбөрийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэхэд оршино.
- 1.4 Алба нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай, Кадастрын зураглал, газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Төрийн албаны тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.
- 1.5 Алба нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэгпэнэ,
- 1.6 Алба нь одөр тутмын үйл ажиллагаагаа хөдөлмөрийн дотоод журам, стратегийн бизнес төлөвлөгөө болон жил, сарын ажлын төлөвлөгөө, ерөнхий

менежерийн үр дүнгийн гэрээ, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын дагуу явуулна.

1.7. Албаны хөдөлмөрийн дотоод журмыг Албаны дарга батална.

Хоёр. Албаны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим.

2.1. Албаны бүтэц, орон тооны хязгаарыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын даргатай зөвшилцөн Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2. Албаны удирдлага нь дарга, орлогч дарга нараас бүрдэнэ.

2.3. Албаны даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.4. Албаны орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцэж, ажилтнуудыг Албаны даргын тушаалаар ажилд томилж, чөлөөлнө.

2.5. Албаны даргын дэргэд байгууллагын зорилт, чи үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг холццэж, даргад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Албаны дарга тогтоонс.

2.6. Албаны дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

2.7. Албаны даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон шийдвэр (тушаал)-ийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтэст хянуулна.

2.8. Альба нь дүүргүүдэд босоо удирдлага бүхий Газрын албадыг байгуулж ажиллуулна. Дүүргийн газрын албаны даргыг дүүргийн Засаг даргын саналыг авч, Албаны дарга томилж, чөлөөлнө.

2.9. Албаны дарга нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, үүрэг хүлээнэ.

2.10. Албаны дарга, түүнийг эзгүйд орлогч дарга нар Албыг төлөөлөн бусад байгууллагатай харьцаж, бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Гурав. Албаны үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг.

3.1. Алба нь газрын харилцааны бодлого, хууль тогтоомжийг Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэхдээ дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

3.1.1. Газрын харилцааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, Албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан, тэдний оролцоотойгоор хэрэгжүүлэх бодлого баримтлах;

3.1.2. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, тусгай хэрэгцээний газар, ХАА-н зориулалттай газар, ногоон бүс, уурхайн эдэлбэр газар, ашигт малтмал, газрын хэвлэй, усны эдэлбэр газар, хот суурингийн эдэлбэр газрын ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.1.3. Газрын кадастрыг эрхлэн, кадастрын зураглал, хэмжилт хийх замаар газрыг бүртгэж, ашиглаж, эзэмшиж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Орчин үсийн газрын харилцааны шаардлагад нийцсон газрын мэдээллийн систем бүрдүүлж, нийслэлийн нутаг дэвсгэрт хийцсэн газар ашиглалт хорс, ургамлын бүрхэвч, ой болон усан сангийн газрын бүх төрлийн судалгаа шинжилгээний үр дүн, баримт бичиг, зураглал болон газрын эрхийн баримт бичгүүдийг хүлээн авч газрын мэдээллийн санд оруулах, архивлах, тэдгээрээр үйлчлэх;

3.1.5. Иргэнд газар өмчлүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулах;

3.1.6. Газрын төлбөр барагдуулах ажлыг зохион байгуулах;

3.2. Алба нь дараах **УУРГИЙГ** хүлээж ажиллана.

3.2.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд нь хяналт тавих;

3.2.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт газар зохион байгуулалтын еренхий төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, газар эзэмших, ашиглах, өмчлөх үйл ажиллагаааг нэгтгэн зангидааж, нутаг дэвсгэрийн зохистой ашиглалтыг бүрдүүлэх;

3.2.3. Нийслэлийн хилийн цэсийн болон бус нутгийн хүрээнд хэрэгжих бүх төрлийн хөтөлбэр, тосолд газар ашиглалтын талаар санал ёгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас батлагдсан төсөл, хөтөлбөрийг хүлээн авч, газар ашиглалтын схем боловсруулан холбогдох шийдвэрийг гаргуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

3.2.4. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хуваарь, Улаанбаатар хот, хот орчмын бус, тосгоны эдэлбэр газрын хилийн цэсийг өөрчлөх, батлах саналыг боловсруулж, Нийслэлийн Засаг даргад өргөн барих;

3.2.5. Газар зохион байгуулалтын еренхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах;

3.2.6. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулах;

3.2.7. Харьяапалын нутаг дэвсгэрт тухайн жилд шинээр эзэмшил, ашиглалт, омчлолд олгогдох газрын байршил, хил заагийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн боловсруулж, нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.8. Газрын төлөв байдал, чанарт улсын хянаа баталгааг тогтоосон журмын дагуу хийх ажлын зохион байгуулах, газар эзэмшигч, ашиглагч, омчлэгчдөд хянан баталгааны паспорт олгох ажлыг зохион байгуулах;

3.2.9. Газрыг нийслэн, дүүргийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох;

3.2.10. Газрыг нийслэл, дүүргийн тусгай хэрэгцээнд авахтай холбоо дуулан солих буюу эргүүлэн авах, хотын өрөнхий төлөвлөгөөний дагуу барилгажуулах талбайгаас нүүлгэн шилжүүлэх тохиолдолд нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлэх;

3.2.11. Газрыг хуульд заасны дагуу албадан чөлөөлөх ажлыг удирдан зохион байгуулах;

3.2.12. Нийслэлийн тазрын кадастрыг эрхлэн, газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллийн үйлчлэх;

3.2.13. Нууцын зэрэглэлтэй зургийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хангах;

3.2.14. Газрын нэгдмэл саннийн үндсэн болон дэлгэрэнгүй ангилал, түүний өөрчлөлт, хөдөлгөөний тайланг жил бүр гаргаж, Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага болон Нийслэлийн Засаг даргад тайлagnah;

3.2.15. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх;

3.2.16. Нийслэгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулан, эрхийн тэрчилгээ олгох;

3.2.17. Газар ашигласны төлбөрийг хууль тогтоомжид заасан журам, хэмжээ баримтлан готгоон, гэрээнд заасан хугацаанд тэсвийн орлогод төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.18. Газрын эрх зүйн баталгаажилтыг хуулийн хүрээнд хийж түйцэтгэх;

3.2.19. Газар эзэмшигүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл шалгаруулах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж явуулах;

3.2.20. Газрын биржийн үйл ажиллагааг эрхлэх;

3.2.21. Дүүргийн Засаг даргын яргот мэдүүлснээр иргэний газар өмчлөхийг хүссэн өргөдлийг хүлээн авч Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай Засаг даргын шийдвэрийн төслийг боловсруулах;

3.2.22. Хуулийн дагуу газрын эрхийг шинэчлэн баталгаажуулах, иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах болон гадаадын байгууллагын газар ашиглах хүсэлтийг хүлсэн авч, зохих журмын дагуу шийдвэрлэх.

3.2.23. Албаны мэргэжлийн боловсон хүчинийг дадлагажуулах, давтан сургах үйл өжиллагаа явуулах, газрын харилцааны зах зээл хөгжсөн орнуудын туршилагаас суралцан нэвтрүүлэх, энэ чиглэлийн төсөл боловсруулж хамтран ажиллах.

3.3. Алба нь дараах эрхтэй байна:

3.3.1. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр газрыг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдон гарсан зөрчил, маргааны хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

3.3.2 Гэзарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр (эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн, эсэхээс үл хамааран) нөхөн телүүлж, түүнийг арилгахтай холбогдсон зардлыг гаргуулах;

3.3.3. Омчийн төрлөөс үл хамаарал Нийслэлийн нутаг дэвсгэр дээр газар эзэмшиж, ашиглаж буй ирэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар, объект, тэдгээрийн барьж байгаа барилгуудад саадгүй нэвтрэн орж холбогдох бичиг баримтыг шаардах, шалгах, зөрчлийг арилгуулах;

3.3.4. Газар эзэмшигч, ашиглагчдад газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх талаар шаардлага тавих, хэрэгжилтэнд хяналт тавих;

3.3.5 Газрын тухай хууль тогтоомж, хотын болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, газар олгоул, ашиглалтын журам зөрчиж гаргасан албан тушаалтны шийдвэрийн талаар дүгнэлт гаргах, улмаар хүчингүй бонцууг их талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал тавих;

3.3.6. Хуульд заасан үндэслэлүүдийн дагуу хуулийн этгээдийн газар ашиглах, эзэмших, омчилх гэрээг хүчингүй болгох санал бэлтгэх;

3.3.7. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олготдсон бусад эрхийг здэлнэ.

Дөрөв. Хариуцлагын тогтолцоо.

5.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах тухай өрөгдөл, хүсэлтийг судлаж, шийдэрлүүлэхдээ хайхрамжгүй хандаж, үндэслэлгүй буруу дүгнэлт гарган, өрөгдөл, хүсэлт таргачийн болон бусад иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хохироосон албан тушаалтанд төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Албаны ажилтан албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглаж, төрийн хууль тогтоомж зэрчсөн тухай иргэд, байгууллагаас мэдээлэл ирсэн тохиолдолц хууль хяналтын байгууллагад шилжүүлж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын
2003 оны 39-р захирамжийн
..... 4-р хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газар нь / наанид "газар" гэх/ байгаль орчны хамгаалах, байгалийн баягийг зохицой ашиглах, нохөн сэргээх, экологийн тэнцлийг хангах талаар явуулж байгаа төрийн боллого, шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэр, ногоон бүсэд хэрэгжүүлэх үүрэг, зорилго бүхий гэрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай, Байгаль орчны багц хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, төреөс байгаль орчны талаар баримтлах боллого, Нийслэлийн Иргэдийн Төмөөлогчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, энхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргад ажлаа тайлматнаа.

1.4. Нийслэлийн Засаг дарга нь газрын орон тооны хязгаарыг тогтоож, даргын томилж, чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвлөлийн үндсэн дээр орлогч даргыг томилж, чөлөөлнэ.

1.6. Газрын дарга нь эрх хэмжээнийхэс асуудлаар туваал гаргана. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажиллагсдыг томилж, чөлөөлно.

1.7. Газар нь үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар газрын даргад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зовтолийг байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэшэхүүн, ажилтах журмыг Газрын дарга батална.

1.8. Газрын дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлэн төсвийг зарцуулна.

1.9. Газрын дарга нь газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гарсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын

холбогдох харьяа агентлаг, нийслэлийг Иргэдийн Төлөөлөгчлийн Хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу үр дүнгийн гэрээ байгуулж, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар зохион байгуулна.

1.10. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хотолбер, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийг Иргэдийн Толоологчлийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг ларгын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биселэлтийн явц үр дүнг хутацаанд нь тайлгахнаа.

2.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт экологийн тэнцлийг хангах, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах бодлого боловсруулахад оролцох.

2.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг хариуцах.

2.5. Нийслэлийн ногоон бүсийн байгалийн иооц баялаг ашиглалтын төлбөр хураамж, үнэлгээг шаардлагатай тохиолдолд шинчлэг боловсруулан батлуулж мөрдүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах.

2.6. Нийслэл хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, дагуул хотуудын төлөвлөлт, байршилт, шинээр байгуулах болон өргөтгэн шинэчлэх, тоноглох үйлдвэр аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн зургийн даалгавар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд экологийн магадлан шинжилгээ гаргүүлж, байгаль орчинд сорог нууц үзүүлэхгүй байх шаардлагыг хангуулах.

2.7. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгоо, барилга байгууламж, тэдээрийг шинчлэх, оргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн иооц баялаг ашиглах аливаа төсөл, арга хэмжээг байгаль орчинд нууцолох байдлын үндэслэлд хамруулах.

2.8. Улаанбаатар хотын ногоон бүсийн байгаль орчин, экологийн толов байдлын тодорхойлох, байгалийн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаар шинжилгээ ухааны үндэслэлтэй хотолбор, төлөвлөгөө,

төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөл, Байгаль орчны сайдын зовлолийн хуралд оруулсан шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.9. Хотын ногоон бүсийн байгалийн баялаг / ашигт мадгмал, ал амьтан, ургамал, хөрс, ой мод, газар, ус гэх мэт/ түүний нөөц болон орчныг бохирдуулах эх үүсвэрийн тоослого, бүртгэл судалгаа гаргах.

2.10. Цацраг идэвхит болон химийн бусад хортой бодис, нефть, хий, үйлдвэрлэлийн хаягдлыг тусгайлан хадгалах, булахад байгаль орчинд сорог нотоо үзүүлэхээс сэргийлэх.

2.11. Байгаль орчиыг хамгаалах, нохон сэргээх улсын даалгавар, захиалгат ажлын биселэлтийг хангуулж гүйцэтгэлийг тогтоосон журмаар гаргуулах.

2.12. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах. Ой, ус, ургамал, ал амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад зориулсан хялбарчилсан гарын авлага, зөвлөмж боловсруулаан шийтийн хүртээл болгох.

2.13. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах.

2.14. Эрхэлж буй ажлын хүрээнд хамаарах зайлшигүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулаан оруулж шийдвэрлүүлэх.

2.15. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамын газрын Хууль зүйн хэлтсээр хянуулах.

Гурав. Газрын эрх

3.1. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдээс байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдээд зохих журмын дагуу арга хэмжээ авах.

3.2. Экологийн хувьд зөвшөөрөн болохгүй үйлдвэр, цех, аж ахуйн нэгжийг шилсээр байгуулахад хориг тавих.

3.3. Байгаль орчин, экологийн төлөв байдлыг үнэлэх, хамгаалах, толорхой асуудлаар магадлагаа гаргахад шаардаадаа мэдсэ баримт, судалгаас холбогдох байгууллага хүмүүсээс гаргахиж авах.

3.4. Хот, дүүргийн төр захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан тогтоол, тушаал, захирамж, заавар, журам, аргачлалт, техник технологийн шийдэл нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжид пийцэхгүй, байгальд сорог нелөө үзүүлэхээр байвал түүний заалтыг хүчингүй болгуулах буюу борчлуулэх тухай шаардах, дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.5. Хотын пугаг дэвсгэр, байгалийн пооц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, экологийн тэнцлийг хадгалах талаар санал дүгнэлтээ Байгаль орчны яам, Нийслэлийн Засаг даргад тавих.

3.6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, улмаар баталгаажай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

3.7. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шигналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.8. Байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хашах асуудлыг засаг даргад тавьж шийдвэрлүүлэх, тэдний шийгмийн асуудлыг шийдвэрлэх.

3.9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.

Лөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй нөхцөлд Монгол Улсын "Төрийн албаны тухай хууль", "Төсвийн байгууллагын удирдлагын санхүүжилтийн тухай хууль"-иуд болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Засаг даргын 2003 оны
99..дүгээр захирамжийн 5-хавсралт

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн мал эмнэлэг, үржлийн газар / цаашид "газар" гэх / нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал амьтнаас гаралтай түүхий эд, бутээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, биэлэлтийг хангуулах үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2. Газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, Малын эмнэлгийн улсын хяналтын дүрэм, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль тогтоомжууд, энэхүү дүрмийг үйл ажиллагаандaa удирдлага болгоно.

1.3. Газар нь үйл ажиллагаандaa хууль дээдлэх, ил тод, шударга ёсыг хангах зарчмыг баримталж ажиллана.

1.4. Газар нь Улсын мал эмнэлэг, үржлийн газраас мэргэжил, арга зүйн удирдлагаар хангагдаж, Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.5. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж банкинд харилцах данстай байна.

1.6. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнэ.

1.7. Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.8. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлэх бөгөөд мэргэжилтнүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

1.9. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх орон тооны бус зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг газрын дарга батлана.

1.10.Газрын дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлж төсвийг зарцуулна.

1.11.Газрын дарга нь байгууллагын нийт ажилтан албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

1.12.Мал аж ахуйн талаар баримтлах бодлого хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх мэдээ, мэдээлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар яам агентлаг, бусад холбогдох газруудтай ажлаа хууль эрх зүйн хэм хэмжээнд уялдуулан зохицуулна.

Хоёр. Газрын үүрэг

2.1.Монгол улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

2.2.Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтмол тайлагнаж ажиллах

2.3.Малын өвчин эмгэгтэй тэмцэх, сэргийлэх, болон үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээг төлевлэх, тесэл боловсруулах, захиалга хэрэгжүүлэх

2.4.Мал амьтны халдварт, гоц халдварт өвчин илэрсэн тохиолдолд дээд шатны байгууллагад мэдэгдэх, өвчиний оношийг тогтоох, тархалтыг зогсоох, түүнийг устгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх

2.5. Мал амьтны халдварт өвчин гарсан үед хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг орон нутгийн төр захиргааны болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран тогтоож, харэгжилтийг хангуулах

2.6.Мал сургийг эрүүлжүүлэх мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, хорио цээрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сурталчилгаа явуулах

2.7.Нийслэлийн нутаг дэвсгэрт гарч байгаа мал, амьтны элдэв өвчинүүдийн гаралт, тархалт, хөдлөл зүйг бүртгэн боловсруулсан иж бүрэн зураглал судалгаатай байх

2.8.Мал амьтнаас хүнд халдвартладаг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

2.9.Мал эмнэлэг, малын үржлийн ажилд шаардагдах эм биобэлдмэл, багаж төхөөрөмжийн захиалга хийх, тэдгээрийг татан авах, хадгалах, хуваарилах зарцуулах, эм биобэлдмэлийн нөөцтэй байх ажлыг зохион байгуулах

2.10. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн өөр хэвшлийн мал эмнэлэг, үржлийн байгууллага, тэдгээрийн мэргэжилтнүүдийн ажилтай танилцаж үүрэг даалгавар өгөх, ажлыг нь дүгнэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

2.11. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн мал эмнэлгийн байгууллага, лабораторийн үйл ажиллагааны тайлан мэдээг улирал, жилээр авч нэгтгэн дүгнэлт гаргах, холбогдох дээд байгууллагад мэдээлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

2.12. Нийслэлийн хэмжээнд мал эмнэлгийн болон үржлийн ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмж, лабораторийн эм урвалжийн төлөвлөлт, санхүүжилтийн асуудлаар нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх

2.13. Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх

2.14. Тус газрын лаборатори нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, экспорт, импортын үйл ажиллагаа явуулагч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ хийж, гэрчилгээ олгох

2.15. Дүүргийн мал эмнэлэг, үржлийн алба аж ахуйн нэгжүүдийн дэргэдэх лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

2.16. Хүнсний бүтээгдэхүүнд хийж буй үзлэг шинжилгээний үнэн зөвд хяналт тавьж, шаардлагатай бол дээж авч баталгаажуулалт хийх

2.17. Лабораторийн оношлогоо, магадлан шинжилгээг батлагдсан арга зүй, стандартын дагуу үнэн зөв хийж баталгаажуулах

2.18. Өвчний онош батлуулах, тодруулах, маргаан шийдвэрлүүлэх зорилгоор зохих журмын дагуу дээж авч шинжлэх баталгаажуулалт гаргах, шаардлагатай гэж үзвэл бусад баталгаат лаборатори, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар дүгнэлт гаргуулна.

2.19. Мал эмнэлэг, мал аж ахуйн боловсон хүчиний сургах, давтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх, туршлага судлуулах гадаад улс орны ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах

2.20. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах

2.21. Малын үргжил селекцийн ажлыг Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж явуулах

2.22. Малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шимт мал бий болгох, нийслэлийн нутаг дэвсгэрт фермерийн аж ахуй байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

2.23. Гойд ашиг шимт малыг бүртгэлд авч гэрчилгээ олгож баталгаажуулах

2.24. Мал эмнэлэг, үрглийн ажил үйлчилгээний талаар Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллах

2.25. Малын удмын сан, эрүүл мэндийн холбогдолтой мэдээ, судалгаа гаргаж хэрэглэгчдийг мэдээллээр хангах

2.26. Өвчтэй мал амьтныг эмчлэх, эмийн худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх

2.27. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуйн зохистой байршилыг бүрдүүлж, мал аж ахуйн эрчимжсэн аж ахуйг хөржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Гурав. Газрын эрх

3.1. Байгууллагын эд хөрөнгө, төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах ба барилга байгууламж, машин техник, тоног төхөөрөмжийг засварлан сэлбэх, шинээр олох, барьж байгуулах, эдэлгээ ашиглалтыг нь сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанар, мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийж баталгаажуулан гэрчилгээ олгох, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн хэрэгжүүлэгч байгууллагуудад хэвлүүлэн тарааж хяналт тавих

3.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлтийн дагуу зөвлөлгөө өгөх, санал хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжлах асуудал боловсруулж шийдвэрлүүлэх

3.4. Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй мал амьтны хашаа, байр, тоног хэрэгсэл, хэвтэр бууцуст цэт, бэлчээр зэргийг зохих нөхцлийг хангаж сайжруулах талаар шаардлага тавих

3.5. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэндэд хор хохирол учруулах, мал амьтны өвчин тараах нь тогтоогдсон болон мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн хэм хэмжээг зерчсан бол хууль, мэргэжлийн хяналтын байгууллагад уламжилж холбогдох арга хэмжээ авахуулах

3.7. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн томоохон зах болон боловсруулах үйлдвэрийн дэргэд шинжилгээний лабораторийг байгуулж ажиллуулах

3.8. ХАА-н гаралтай бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын гаргасан зөрчил дутагдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж сэргэжилүүлэг өгөх, зохих заавар журмын дагуу ариутгал халдвартайжүүлэлт хийх

3.9.Илэрсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар хяналтын байгууллагатай хамтарч асуудал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх

3.10.Төрөл бүрийн мал амьтан, түүнээс гаралтай түүхий эд хүнсний бүтээгдэхүүн, тэжээлээс дээж авч оношлогоо шинжилгээ хийх, дүгнэлт гаргах

3.11.Холбогдох дээд байгууллагын эрх опгосноор гадаад орны мэргэжлийн алба, байгууллагатай мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний чиглэлээр харилцаа тогтоож ажиллах

Дөрөв. Хүлээх хариуцлага

4.1.Газрын дарга, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.